



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 11/12

Мандалговь

Г

Дэмжлэг үзүүлэх тухай

Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.2.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.12, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 7 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Эртнээс өвлөгдөн уламжлагдаж ирсэн ардын уламжлалт урлагийн төрлүүдийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Дуу хуурын өлгий нутаг” хүүхдийн урлагийн боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсүгэй

Хоёр. Уг хөтөлбөрийн хүрээнд “Бид дуу хуурын өлгий нутгийн үр сад” арга хэмжээг Монгол Улсын Алдарт дуучин, Зууны манлай уртын дуучин Ж.Дорждагвуун нэрэмжит болгон 2017 оны 5 дугаар сарын 5-7-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулсугай.

Гурав. Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах 1000000 /Нэг сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

020000451